

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/057/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-17
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	20-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21-22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.САРУУЛТӨГС ТАНАА**

2025.02.14 № 02А-2025/057/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд албан хэрэгцээнд ашиглаж буй Тоёото 4 раннер маркийн автомашины сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний төлбөрт 28,944.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын орлогын зарцуулалтын эрхийг эдийн засгийн ангиллаар бус бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд, архивын үйлчилгээний орлогын зарцуулалтын

432502130

эрхийг бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд бөөн дүнгээр тавьж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад зардлын бүлэг, зүйлээр тавих хяналтыг сулруулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>82,385,463.72</u>	<u>116,127,347.17</u>
33	АВЛАГА	53,501,629.72	83,081,567.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	53,501,629.72	41,254,389.72
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	41,827,178.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,883,834.00	33,045,779.45
354	Хангамжийн материал	28,883,834.00	33,045,779.45
35410	Бичиг хэргийн материал	2,693,850.00	2,599,095.45
35420	Аж ахуйн материал	21,038,984.00	28,259,184.00
35440	Түлш, шатах тослох материал	4,071,000.00	1,107,500.00
35470	Бусад хангамжийн материал	1,080,000.00	1,080,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>341,011,893.37</u>	<u>288,754,950.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	341,011,893.37	288,754,950.18
392	Биет хөрөнгө	322,793,893.37	269,216,950.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	120,724,015.00	120,724,015.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,801,338.40	-9,529,606.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	264,200,000.00	264,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-155,354,166.73	-196,470,833.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	315,167,911.60	346,875,871.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	-242,023,252.99	-277,828,852.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,135,084.72	38,135,084.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,254,359.83	-16,888,729.05
393	Биет бус хөрөнгө	18,218,000.00	19,538,000.00
39301	Програм хангамж	00.00	1,320,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,218,000.00	18,218,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>423,397,357.09</u>	<u>404,882,297.35</u>
413	Өглөг	00.00	92,986.84
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	92,986.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>423,397,357.09</u>	<u>404,882,297.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	423,397,357.09	404,789,310.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	157,557,480.26	157,557,480.26
51101	Өмч: - төрийн	157,557,480.26	157,557,480.26
512	Хуримтлагдсан үр дүн	259,272,111.83	240,664,065.25
51210	Өмнөх үеийн үр дүн	259,272,111.83	259,272,111.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,608,046.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,567,765.00	6,567,765.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>423,397,357.09</u>	<u>404,882,297.35</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,272,287,687.68	1,973,993,863.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,187,523.18	111,157,337.54
120	Нийтлэг татварын бус орлого	164,187,523.18	111,157,337.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,187,523.18	110,514,901.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,865,184.86	102,833,741.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,108,100,164.50	1,862,836,525.95
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,038,785,500.00	1,528,579,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,038,785,500.00	1,528,579,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,095,664.50	332,989,408.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	142,313,295.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	3,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,095,664.50	186,876,113.00
1330	Төсвийн захирагчдаас	219,000.00	1,267,217.25
133003	Хөрөнгийн	219,000.00	1,267,217.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,264,590,179.40	1,992,601,910.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,264,590,179.40	1,992,601,910.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,208,577,895.26	1,726,101,799.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,626,361.06	1,195,935,637.70
210101	Үндсэн цалин	524,034,377.15	599,096,154.05
210102	Нэмэгдэл	221,200,167.04	411,328,766.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,563,926.93	105,471,137.59
210104	Урамшуулал	59,827,889.94	80,039,579.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,131,577.92	151,053,191.68
210201	Тэтгэврийн даатгал	72,644,540.52	95,969,049.83
210202	Тэтгэмжийн даатгал	8,507,962.06	19,110,032.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,770,432.74	6,918,062.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,651,858.68	6,260,105.53
210205	Эрүүл мэндийн даатгал	16,556,783.92	22,795,941.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,175,000.00	7,477,800.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,141,900.00
210302	Түлш, халаалт	00.00	3,349,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,986,400.00
210304	Байрны түрээс	3,175,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,832,640.00	25,337,165.93

210401	Бичиг хэрэг	8,793,910.00	9,431,421.80
210402	Тээвэр, шатахуун	17,349,000.00	10,363,064.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	269,280.00	373,180.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,187,710.00	5,169,500.00
210408	Бараа материал акталсны зардал	11,232,740.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,648,000.00	34,584,805.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	110,000.00	710,734.00
210604	Урсгал засвар	21,538,000.00	33,874,071.88
2107	Томилолт, зочны зардал	12,801,830.00	23,474,096.00
210702	Дотоод албан томилолт	12,801,830.00	23,474,096.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,967,966.52	175,087,349.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,894,986.52	174,448,729.90
210803	Даатгалын үйлчилгээ	52,000.00	157,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,900.00	7,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
210807	Газрын төлбөр	13,080.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,394,519.76	113,151,751.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,900.00	27,866,849.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,183,619.76	85,284,902.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,012,284.14	266,500,111.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	144,853,893.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,900,000.00	6,698,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	138,155,193.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,036,269.64	121,646,218.07
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	25,184,155.14	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,852,114.50	116,339,575.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,076,014.50	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,076,014.50	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,697,508.28	-18,608,046.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,697,508.28	-18,608,046.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,213,244,719.64	1,934,823,112.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,363,555.14	115,080,981.82
120	Нийтлэг татварын бус орлого	105,363,555.14	115,080,981.82

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,363,555.14	115,080,981.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,363,555.14	115,080,981.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,107,881,164.50	1,819,742,130.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,038,785,500.00	1,528,579,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,038,785,500.00	1,528,579,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,095,664.50	291,162,230.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	142,313,295.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	3,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,095,664.50	145,048,935.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,165,311,119.64	1,909,476,312.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,165,311,119.64	1,909,476,312.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,109,298,835.50	1,642,976,201.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,625,922.06	1,195,935,637.70
210101	Үндсэн цалин	524,033,938.15	599,096,154.05
210102	Нэмэгдэл	221,200,167.04	411,328,766.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,563,926.93	105,471,137.59
210104	Урамшуулал	59,827,889.94	80,039,579.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,132,016.92	150,960,204.84
210201	Тэтгэврийн даатгал	72,644,799.52	95,876,062.99
210202	Тэтгэмжийн даатгал	8,508,142.06	19,110,032.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,770,432.74	6,918,062.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,651,858.68	6,260,105.53
210205	Эрүүл мэндийн даатгал	16,556,783.92	22,795,941.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,175,000.00	7,477,800.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,141,900.00
210302	Түлш, халаалт	00.00	3,349,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,986,400.00
210304	Байрны түрээс	3,175,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,617,886.52	16,203,578.13
210401	Бичиг хэрэг	8,819,676.52	4,462,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,349,000.00	5,649,628.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	269,280.00	491,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,179,930.00	5,599,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,797,000.00	51,941,574.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,228,000.00	22,165,012.40
210604	Урсгал засвар	21,569,000.00	29,776,561.60
2107	Томилолт, зочны зардал	12,801,830.00	23,474,096.00

210702	Дотоод албан томилолт	12,801,830.00	23,474,096.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,938,280.00	168,274,385.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,865,300.00	167,635,765.00
210803	Даатгалын үйлчилгээ	52,000.00	157,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,900.00	7,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	473,000.00
210807	Газрын төлбөр	13,080.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,900.00	28,708,925.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,900.00	28,558,925.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,012,284.14	266,500,111.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	144,853,893.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,900,000.00	6,698,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	138,155,193.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,036,269.64	121,646,218.07
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	25,184,155.14	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,852,114.50	116,339,575.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,076,014.50	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,076,014.50	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	47,933,600.00	25,346,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	47,933,600.00	25,346,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,933,600.00	25,346,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,933,600.00	25,346,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,933,600.00	25,346,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-47,933,600.00	-25,346,800.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,689,480.26	813,751.30	-38,766,441.77	110,736,789.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,689,480.26	813,751.30	-38,766,441.77	110,736,789.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,095,831.82	68,095,831.82
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	259,272,111.83	423,397,357.09
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	259,272,111.83	423,397,357.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	259,272,111.83	423,397,357.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,608,046.58	-18,608,046.58
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	240,664,065.25	404,789,310.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,653,579,900.00	1,527,321,306.06	126,258,593.94	92.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,653,579,900.00	1,527,321,306.06	126,258,593.94	92.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,512,526,000.00	1,386,267,413.06	126,258,586.94	91.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,186,699,300.00	1,070,451,459.50	116,247,840.50	90.20
210101	Үндсэн цалин	659,449,600.00	598,126,578.45	61,323,021.55	90.70
210102	Нэмэгдэл	454,294,900.00	286,814,163.95	167,480,736.05	63.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,624,900.00	105,471,137.59	-74,846,237.59	344.40
210104	Урамшуулал	42,329,900.00	80,039,579.51	-37,709,679.51	189.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,276,300.00	134,928,727.78	8,347,572.22	94.17

210201	Тэтгэврийн даатгал	97,427,800.00	85,300,729.85	12,127,070.15	87.55
210202	Тэтгэмжийн даатгал	11,462,100.00	17,712,901.76	-6,250,801.76	154.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,731,000.00	5,731,000.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,731,200.00	5,689,708.43	41,491.57	99.28
210205	Эрүүл мэндийн даатгал	22,924,200.00	20,494,387.74	2,429,812.26	89.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,477,800.00	7,477,800.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,141,900.00	2,141,900.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	3,349,500.00	3,349,500.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,986,400.00	1,986,400.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,046,200.00	4,806,000.00	240,200.00	95.24
210401	Бичиг хэрэг	1,028,400.00	720,600.00	307,800.00	70.07
210402	Тээвэр, шатахуун	3,414,900.00	3,323,600.00	91,300.00	97.33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	163,800.00	193,400.00	-29,600.00	118.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	439,100.00	568,400.00	-129,300.00	129.45
2105	Нормативт зардал	165,000.00	00.00	165,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	165,000.00	00.00	165,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,370,400.00	34,370,400.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,940,300.00	18,180,278.40	-239,978.40	101.34
210604	Урсгал засвар	16,430,100.00	16,190,121.60	239,978.40	98.54
2107	Томилолт, зочны зардал	2,944,100.00	2,944,100.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	2,944,100.00	2,944,100.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,910,000.00	102,730,000.00	180,000.00	99.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,851,300.00	102,671,300.00	180,000.00	99.82
210803	Даатгалын үйлчилгээ	51,000.00	51,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,700.00	7,700.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,636,900.00	28,558,925.78	1,077,974.22	96.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,636,900.00	28,558,925.78	1,077,974.22	96.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,053,900.00	141,053,893.00	7.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,053,900.00	141,053,893.00	7.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,898,700.00	2,898,700.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	138,155,200.00	138,155,193.00	7.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,653,579,900.00	1,643,660,881.82	9,919,018.18	99.40

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,528,579,900.00	1,528,579,900.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,528,579,900.00	1,528,579,900.00	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	125,000,000.00	115,080,981.82	9,919,018.18	92.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,000,000.00	115,080,981.82	9,919,018.18	92.06
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43	36	7	83.72
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37	30	7	81.08
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	291,162,230.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291,162,230.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	282,055,588.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,366,907.22
210102	Нэмэгдэл	124,366,907.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,328,748.04
210201	Тэтгэврийн даатгал	11,872,604.12
210202	Тэтгэмжийн даатгал	1,397,131.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,187,062.10
210204	Ажилгүйдлийн даатгал	570,397.10
210205	Эрүүл мэндийн даатгал	2,301,553.51
2104	Хангамж, бараа материалын зардал	11,397,578.13
210401	Бичиг хэрэг	3,741,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,326,028.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	298,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,031,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,698,174.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,111,734.00
210604	Урсгал засвар	13,586,440.00
2107	Томилолт, зочны зардал	20,529,996.00
210702	Дотоод албан томилолт	20,529,996.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,584,185.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,684,265.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,793,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3800000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,800,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,306,642.31
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	291162230.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	291,162,230.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	142,313,295.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,048,935.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газар /цаашид аймгийн ГХБХБГ гэх/ нь 2024 онд "Сэлэнгэ аймгийн газар нутгийн нөөц чадавхыг дэмжин тэтгэсэн эдийн засгийн хувьд ашигтай, экологийн хувьд тэнцвэртэй газар ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, эрх зүйн баталгаатай газар өмчлөл, эзэмшилт, ашиглалтыг бий болгоно." гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГЗБГЗЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд дурдагдсан алдаа, зөрчил, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт болон шилэн дансны хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ГХБХБГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь ГЗБГЗЗГ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн ГХБХБГ-ын мөрдөж байгаа "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ГХБХБГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,515.0 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	53,501.60	83,081.60	29,580.00
Бараа материал	28,883.80	33,045.80	4,162.00
Үндсэн хөрөнгө	341,011.90	288,754.90	(52,257.00)
Нийт хөрөнгө	423,397.30	404,882.30	(18,515.00)
Өр төлбөр	-	92.90	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	423,397.30	404,789.30	(18,608.00)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	423,397.30	404,882.30	(18,515.00)

Дээрх хүснэгтээс үзэхэд нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна.
Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 29,580.0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны 53,501.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, Барилгын хөгжлийн төвөөс

авах барилга захиалагчийн техник хяналтын 83,081.6 мянган төгрөгийн үлдэгдлийг нэмэлт санхүүжилтийн данснаас төсөвт төвлөрүүлж, авлага үүсгэснээс шалтгаалсан байна.

- Бараа материалын дансны үлдэгдэл 33,045.8 мянган төгрөг болж 4,162.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 123,097.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ГЗБГЗЗГ-аас 1,267.2 мянган төгрөгийн бараа материал, Содмонгол групп ХХК-аас гэрээнд заасны дагуу 642.5 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг үнэ төлбөргүй хүлээн авч, 120,845.3 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 288,754.9 мянган төгрөг болж 52,257.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 25,346.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авсан, 7,681.1 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 85,284.9 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ГХБХБГ нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,917,344.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас **2,907,813.4** мянган төгрөгөөр бууруулж, **1,554,630.6** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 321,716.4 мянган төгрөг,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 40,214.6 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 79,744.6 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 28,800.0 мянган төгрөг,
- Урсгал шилжүүлгийг 74,593.6 мянган төгрөг зэрэг нийт **545,099.5** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 39,680.8 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардлыг 38,917.3 мянган төгрөг,
- Нормативт зардлыг 25,105.0 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 716,154.4 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 6,955.9 мянган төгрөг,
- Лабораторийн барилга шинээр барихаар төлөвлөсөн 2,100,000.0 мянган төгрөг гэх мэт.

Тайлант оны батлагдсан төсвийг 98,949.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж /Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 40,489.3 мянган төгрөгөөр, хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 3,034.8 мянган

төгрөгөө, урсгал шилжүүлгийг зардлыг 60,460.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглахтай холбоотой зардлыг 4,671.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 363.1 мянган төгрөгөөр бууруулсан байна./1,653,579.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,528,579.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 125,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,528,579.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 115,080.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 9,919.0 мянган төгрөгөөр тасарсан нь газартай холбоотой 2003-2023 оны мэдээллийг цахим мэдээллийн санд оруулан, е-монголиа аппликейшнээр иргэд, аж ахуйн нэгж байгууллага үнэ төлбөргүй мэдээлэл авдаг болсноос шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,527,321.3 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 126,258.6 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,409,674.70	1,283,416.10	126,258.60	92.40
2	Байр ашиглалтын үйлчилгээ	7,851.30	7,851.30	0.00	100.00
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	141,053.90	141,053.90	0.00	100.00
4	Барилгын техник хяналт	95,000.00	95,000.00	0.00	100.00
	Дүн	1,653,579.90	1,527,321.30	126,258.60	92.40

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130008402 тоот дансанд нийт 291,162.2 мянган төгрөг /Барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын орлогоос 186,876.1 мянган төгрөг, 2023 оны ажлын гүйцэтгэл, үр дүнгийн шагнал 3,800.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 142,313.3 мянган төгрөг/-ийн санхүүжилт төвлөрч, 285,855.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 5,306.6 мянган төгрөгийг жилийн эцэст ГЗБГЗЗГ-т төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу аймгийн ГХБХБГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ГХБХБГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,264,590.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,645.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ГХБХБГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин хөлстэй холбоотой 3 зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	4,270.0	3	4,270.0	100.0
Нийт дүн	3	4,270.0	3	4,270.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн буюу холбогдох бусад байгууллагын шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын 95,000.0 мянган төгрөгийн зарцуулалтын эрхийг эдийн засгийн ангиллаар бус бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд, архивын үйлчилгээний орлогын 18,676.8 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд бөөн дүнгээр тавьж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад зардлын бүлэг, зүйлээр тавих хяналтыг сулруулж байна.
2. Сэлэнгэ аймгийн Татварын газрын 2024 оны 324 дүгээр албан бичгийн дагуу албан хаагчдад 5 жилд 1 удаа олгож байгаа мөнгөн урамшууллаас 13,815.5 мянган төгрөгийн ХХАОТ суутгасан байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар мөнгөн гүйлгээний тайланд 1,320.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авсныг зардлаар тайлагнасан, үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 915.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан зэрэг нийт 2,235.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 11,018.7 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 167.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 10,850.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1.Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас нягтлан бодогч П.Уранчимэгт 167.9 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ, 20.2.5: ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Газартай холбоотой 2003-2023 оны мэдээллийг цахим мэдээллийн санд оруулан, е-монголиа аппликейшнээр иргэд, аж ахуйн нэгж байгууллага үнэ төлбөргүй мэдээлэл авдаг болсон нөхцөл байдлыг тооцолгүйгээр буюу өөрийн үйл

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллагааны орлогыг бодитоор төлөвлөөгүйгээс төлөвлөгөөг 9,919.0 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална, 5.1.2: Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг нөхцөл байдал, тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Цалин хөлс, нэмэгдэл урамшлын батлагдсан төсвөөс ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 931.8 мянган төгрөгийг зардлын ангилал хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд цалин илүү тайлагнасан.	1	1,320.0					1	1,320.0				
Мөнгөн гүйлгээний тайланд биет бус хөрөнгө худалдан авсан дүнг зардлаар тайлагнасан.	1	915.4					1	915.4				
Дүн	2	2,235.4	-	-	-	-	2	2,235.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолтын зардлыг илүү тооцож олгосон.	1	167.9	1	167.9									
Өөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн	1	9,919.0			1	9,919.0							
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	931.8			1	931.8							
Дүн	3	11,018.7	1	167.9	2	10,850.8							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-